

2025 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2025-09-23

Өндөртөлгой

Үүргийн биелэлтийг Arial-11, 12 фонтоор бичиж, **2025 оны 09 дүгээр сарын 30-ны “Мягмар” гарагт** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн (ERP Б.Одбаяр)-д албан бичгээр болон word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд онцгой анхаарч биелэлтийг ирүүлэхдээ нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 8.6 дахь хэсэгт заасан дараах шаардлагын дагуу тайлагнахыг анхаарна уу

8.6.Байгууллагаас ирүүлэх бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, холбогдох тайлан, мэдээ нь дараах шаардлагыг хангасан байна:

- 8.6.1. үйл ажиллагааны гүйцэтгэлийг бүрэн багтаасан, тайлант хугацааг бүрэн хамруулсан байх;
8.6.2. үг үсгийн болон хэл найруулгын хувьд алдаагүй, тоо баримт зөрөөгүй байх;
8.6.5. тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгасан байх;
8.6.6. хийсэн ажлыг бүрэн хамруулж, үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийн үндэслэл, шалтгааныг тодорхой гаргасан байх;
8.6.7. хэрэгжилтийг 2000 (хоёр мянган) тэмдэгтэд багтааж, үр дүн, үр нөлөөг тайлагнах;

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Улс, нийслэлийн төсөв, гадаадын зээл, тусламж, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтаар хэрэгжиж буй бүх салбарын ажлуудаа эрчимжүүлэх.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, СТСХ, ТХҮХ, ХААА, нийт байгууллагууд
2	Захиалагчийн хяналт тавьж буй байгууллагууд хөрөнгө оруулалтын ажлын чанар, стандартын хяналтыг сайжруулах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, СТСХ, ТХҮХ, ХААА, нийт байгууллагууд
3	Төсвийн орлого бүрдүүлэх ажлыг бүх шатанд эрчимжүүлж, төсвийн орлогын ногдол төлөлтийг бүрэн хийх.	СТСХ, Татварын хэлтэс
4	Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн дагуу төсвийн зардлын хэмнэлтийг хэрэгжүүлэн, төсвийн сахилга бат, дотоод хяналтыг сайжруулах.	СТСХ, Дотоод аудитын алба, нийт байгууллагууд
5	Ухсан нүх, эвдэрч гэмтсэн авто зам, явган зам, талбайг нөхөн сэргээх, засварлах ажлаа чанартай гүйцэтгэж, хэрэгжилтэд хяналт шалгалт хийх.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, холбогдох инженерийн хангамжийн байгууллагууд
6	Дүүргийн хэмжээнд гэрэлтүүлгийн асалтад хяналт тавьж, асалтыг 100 хувьд хүргэх.	Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
7	Иргэдийг ус, дулаан, цахилгаан эрчим хүчээр найдвартай хангаж, тасалдуулахгүй байхад онцгой анхаарч ажиллах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, инженерийн хангамжийн байгууллагууд
8	Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 16 дугаар тэмдэглэлийн дагуу тарваган тахал өвчний хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг ханган, оношилгоо, эмчилгээний чадавхыг сайжруулж, авто тээврийн шалган нэвтрүүлэх цэгүүдэд хяналт тавих.	Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Мал эмнэлгийн тасаг
9	Явган замын засвар, шинэчлэлийн ажлыг эрчимжүүлэх, 2026 онд дүүрэгт хийгдэх явган зам, дугуйн замын зураг төсвийн ажлыг гүйцэтгүүлэхэд шаардлагатай мэдээллийг бэлтгэх.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
10	2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулагдах хот нийтийн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудтай уулзах уулзалтад оролцох.	Багахангай тохижилт ОНӨААТҮГ
11	Нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлыг цэвэрлэх тээвэрлэх ажлыг шуурхай зохион байгуулах.	Багахангай тохижилт ОНӨААТҮГ
12	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1084 дүгээр захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Онцгой байдлын хэлтэс
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
13	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2025 оны 11, 12 дугаар саруудад нутгийн захиргааны байгууллагуудад очиж ажиллах түл бэлтгэлийг сайтар хангах.	ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц ЗДТГ-ын бодлогын хэлтсүүд
14	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/237 дугаар захирамжийн дагуу авч хэрэгжүүлсэн ажлын хэрэгжилтийг нэгтгэн УБЗАА-нд	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Хороод

	хүргүүлэх.	
15	Дүүргийн аж ахуйн нэгж, байгууллагуудад ажиллаж буй гадаадын иргэн, ажиллах хүчний талаар хороод тус бүрээр гарган танилцуулах. (хүний тоо, визний мэдээлэл төрөл, ажиллах хугацаа г.м)	Хороод
16	2025 оны 10, 11 дүгээр саруудад зохион байгуулагдах архивын Улсын үзлэгт сайтар бэлтгэн, амжилттай шалгагдахад анхаарч ажиллах.	ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц Архивын хэлтэс, нийт байгууллагууд
17	2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулагдах “Оролцоод хөгжье” мэтгэлцээний тэмцээний бэлтгэлийг ханган, ААНБ-уудын удирдах албан тушаалтнууд, ажилтан, албан хаагчид, иргэдийг идэвхтэй оролцуулах.	Дүүргийн ИТХ, ЗДТГ, нийт байгууллагууд
18	2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн “Ахмадын баяр”-ын арга хэмжээний бэлтгэлийг хангах, харьяалах ахмадууддаа хүндэтгэл үзүүлэх.	НХХ, нийт байгууллагууд
19	2025 оны 09 дүгээр сарын 24, 25-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Төлөөлөгчийн цаг” арга хэмжээнд холбогдох албан тушаалтнууд оролцох.	ЗДТГ, нийт байгууллагууд
20	Дүүргийн 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх.	Онцгой байдлын хэлтэс, ХААТ, нийт байгууллагууд
21	“Найрамдал-2” төслийг хэрэгжүүлэх хүрээнд байгуулагдсан Ажлын хэсэг ажлаа эрчимжүүлэн, ТЭЗҮ боловсруулах бэлтгэлийг хангах.	ЗДТГ, Холбогдох Ажлын хэсэг

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

ХЯНАСАН
ГАДААД ХАРИЛЦАА ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.ГЭРЭЛЦОЛМОН

БОЛОВСРУУЛСАН
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Б.ОДБАЯР